



Зураг 1. Үйлдвэрлэлийн процессоос гарсан уур тагны амсраар гадагшилж байна.



Зураг 2 - Үйлдвэрлэлийн процессоос гарсан уур үйлдвэрлэлийн орчинд ажилтан өртөхүйц нам түвшинд байна.

2004 оны 04-р сарын 12-ны өдөр АНУ-ын Далтон Жоржиа хотын нэгэн компани гэрээний дагуу цианид агуулсан химийн бодис үйлдвэрлэдэг байсан. Энд гэнэтийн хүчтэй урвалын нөлөөгөөр шатамхай болон хортой аллилын спирт, аллилын хлорид агаарт алдагдсан байна. Зарим материал битүүмж муутай тагны амсраар (Зураг 1) алдагдсан бол ихэнх нь реакторын сууринд ойр байрлах даралтын дискний хий зайлуулах гаралтаар алдагджээ (Зураг 2). Химийн бодис алдагдсаны улмаас ойролцоо байрлах 200 гаруй айл өрхийг нүүлгэн шилжүүлэх шаардлагатай болсон байна.

Нэг ажилтан химийн бодисын түлэгдэлтэд өртөж, 154 хүн химийн бодисын хордлого тайлах арга хэмжээ болон эмчилгээнд хамрагдсаны 15 нь аврах багийн ажилтан байжээ. (Эх сурвалж: CSB сурвалжлага 2004-09-I-GA. Зургийн эх үүсвэр: CSB “Химийн Урвалын Аюул” видео)

АНУ-ын өөр нэгэн компанид хяналтын байгууллагаас үзлэг шалгалт хийж, үйлдвэрлэлийн процессын аюулгүйн хавхлагуудын хий зайлуулах байршил аюултай байна гэж мэдэгджээ. Хэдийгээр хийг гадагш зайлуулж байсан боловч хий зайлуулах цэг нь үйлдвэрийн байгууламжийн гарах хаалганы эгц дээр байрласан байжээ. Хий зайлуулах процесс явагдаж байх үед байгууламжаас ажилтан гарч ирсэн тохиолдолд тухайн процессоос гарсан бодисын дэгдэлтэд шууд өртөх боломжтой байсан.

Та мэдэх үү?

1. Үйлдвэрлэлийн процесс эсвэл сантехникийн шугамд ашигладаг даралт суллах хэрэгслүүдийн хийг зайлуулахдаа аюулгүй байршилыг сонгох хэрэгтэй. Ингэхдээ тухайн бодисоос хамаарна.
2. Битүүмж муутай тагны амсраар хортой бодис алдагдвал үйлдвэрийн орчинд байгаа ажилтнууд өртөж болзошгүй. Хэт даралтыг зайлуулах цорын ганц цэг нь даралт суллах хэрэгсэл байх ёстой.
3. Даралт суллах хэрэгслээс ялгарч болзошгүй бодисын мэдээлэл тодорхой байх ёстой бөгөөд аюулгүй ажиллагаа, байгаль орчны чухал мэдээлэлд тооцож баримтжуулах шаардлагатай.
4. Хорт хий зайлуулах аюулгүй байршил гэдэг нь ууршилттай бодисыг агаарт сарниах, шингэн бодисыг хязгаарлан барих боломжтой байна.
5. Алдагдсан бодис бөөгнөрч хуримтлагдвал шатамхай эсвэл хортой бодис агаарт хуралдсаны улмаас ноцох эсвэл ажилтан, ойр хавийн ард иргэдэд хор хөнөөл учруулах аюултай.
6. Тухайн хэсгийн бусад үйлдвэрлэлийн процесс, тоног төхөөрөмжийг өөрчлөхдөө хий зайлуулах процессын тархалтад үзүүлэх нөлөөг нь шалга.

Та юу хийж болох вэ?

1. Байгууламж дотор тойрох үзлэг хийх явцдаа даралт суллах хэрэгслүүдийн гаралтыг шалга.
Ингэхдээ дараах зүйлсийг анхаар:
 - a. Даралтын шугамыг тэмдэглэсэн шошго байна уу?
 - b. Хүнд аюул учруулах боломжтой юу?
 - c. Ойролцоох тоног төхөөрөмжүүд шатамхай эсвэл хортой хийн замыг хаасан байна уу?
 - d. Дээрх асуултуудын аль нэгэнд “Тийм” гэж хариулсан бол ахлах ажилтандаа мэдэгд.
2. Хэрэв үйлдвэрлэлийн процессийн эсвэл хий зайлуулах гаралт ажилтан өртөхүйц нам түвшинд байрласан байгаа бол мөн мэдээл.
3. Тоног төхөөрөмж болон шугам хоолойн бүх нээлхийг (таг, шингэн цэнэглэх амсар гэх мэт) бүрэн чангалсан буюу хий зайлуулах систем зохих журмын дагуу ажиллаж буй эсэхийг нягтал.
4. Өөрчлөлтийн Менежментийн (МОС) материалтай танилцах үед хий зайлуулах цэгийн байршлын нарийн мэдээллийг асуу. Хий зайлуулах байршил нь хий, уур, хуримтлагдсан шингэнийг сарниах боломжтой байх ёстой.

**Даралт суллах хэрэгслийн хий зайлуулах байршил аюулгүй байх ёстой.
Тухайн байршил нь бүрэн аюулгүй эсэхийг нягтал.**